



УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2015 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 1750

Улаанбаатар хот

Тодорхойлолт, загвар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.10, 9.1.2, Иргэний бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, УБЕГ-ын даргын 2014 оны 816 дугаар тушаалаар батлагдсан “Монгол Улсын иргэний үнэмлэх олгох, түүнд мэдээлэл оруулах, бүртгэл хөтлөх журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Монгол Улсын иргэний цахим үнэмлэхийн бичил санах ойд мэдээлэл оруулах картын тодорхойлолт”-ыг нэгдүгээр, “Монгол Улсын иргэний үнэмлэхийн бичил санах ойд мэдээлэл оруулах картын загвар”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Карт ашиглалтын тоног төхөөрөмжийн бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Тамгын газрын дарга С.Алтангэрэл, Мэдээллийн технологийн газрын дарга М.Алтанзүрх нарт даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг иргэний улсын ахлах бүртгэгч, улсын бүртгэгч, бүртгэлийн хяналтын улсын байцаагч нарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүртгэлийн хяналтын газрын дарга Н.Пүрэвжаргал, Иргэний бүртгэл, гадаад паспортын газрын дарга Д.Энхцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ПҮРЭВДОРЖ

C:/documents/tushaalin tusul.

00004068

**МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ЦАХИМ ҮНЭМЛЭХИЙН
БИЧИЛ САНАХ ОЙД МЭДЭЭЛЭЛ ОРУУЛАХ КАРТЫН
ТОДОРХОЙЛОЛТ**

Монгол Улсын иргэний үнэмлэхийн бичил санах ойд мэдээлэл оруулах зориулалт бүхий карт /цаашид «карт» гэх/ нь 85.60 мм х 53.98 мм хэмжээтэй, поликарбонат материалаар хийгдсэн, олон улсын стандарт /ISO 7810, ISO 10373/-ыг хангасан байна.

Нэг. Картын нүүрэн тал

1.1. Иргэний үнэмлэхийн бичил санах ойд мэдээлэл оруулах картын нүүрэн талд олон улсын стандарт /ISO/IEC 19794-5/-ын шаардлага хангасан тэгш өнцөгт хөх цэнхэр өнгийн суурь дээр «Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР» гэсэн бичвэрийг картын дээд хэсэгт голлуулан, карт эзэмшигч улсын бүртгэлийн байгууллагын логог баруун дээд хэсэгт, «бичил санах ой буюу контакт бүхий чип»-ийг баруун захад, картын бичвэрийг ар дэвсгэртэй нягт уялдуулан цагаан өнгөөр, дахин давтагдахгүйгээр үргэлжилсэн алхан хээ ууссан бүдэг хөх өнгийн дэвсгэр дээр картын доод хэсэгт тус тус байрлана.

1.2. Картын нүүрэн талын дүрслэл, бичиглэл нь дараах хэмжээс, нөхцлийг хангасан байна. Үүнд:

1.2.1. “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн бичвэр нь иргэний үнэмлэхийн дээд талаас 6 мм зайд, “УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР” гэсэн бичвэр нь иргэний үнэмлэхийн дээд талаас 9 мм зайд голлон цагаан өнгөөр хэвлэгдсэн байна;

1.2.2. Улсын бүртгэлийн ерөнхий газрын лого нь 14.5 мм өндөр, 10 мм өргөнтэй, иргэний үнэмлэхийн дээд талаас 2 мм, зүүн талаас 2.5 мм зайд байрлана;

1.2.3. картын баруун доод хэсэгт 8 орон бүхий сериалын дугаар картын доод талаас 7 мм зайд, зүүн талаас 7 мм зайд алхан хээний дээд талд цагаан өнгөөр байрлана;

1.2.4. картын баруун талаас 5 мм, доод талаас 1.5 мм зайд 1.75 мм өндөр, 2.75 мм өргөнтэй бичил санах ой буюу чип байрлана;

1.2.5. картын доод талаас 1 мм зайд 85.60 мм урттай алхан хээ байрласан байна;

1.2.7. “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг”, “УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР” гэсэн бичвэрийн доор “Аймаг /Нийслэл; Сум/ Дүүрэг; Хороо”

**МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ЦАХИМ ҮНЭМЛЭХИЙН
БИЧИЛ САНАХ ОЙД МЭДЭЭЛЭЛ ОРУУЛАХ КАРТЫН
ТОДОРХОЙЛОЛТ**

Монгол Улсын иргэний үнэмлэхийн бичил санах ойд мэдээлэл оруулах зориулалт бүхий карт /цаашид «карт» гэх/ нь 85.60 мм х 53.98 мм хэмжээтэй, поликарбонат материалаар хийгдсэн, олон улсын стандарт /ISO 7810, ISO 10373/-ыг хангасан байна.

Нэг. Картын нүүрэн тал

1.1. Иргэний үнэмлэхийн бичил санах ойд мэдээлэл оруулах картын нүүрэн талд олон улсын стандарт /ISO/IEC 19794-5/-ын шаардлага хангасан тэгш өнцөгт хөх цэнхэр өнгийн суурь дээр «Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР» гэсэн бичвэрийг картын дээд хэсэгт голлуулан, карт эзэмшигч улсын бүртгэлийн байгууллагын логог баруун дээд хэсэгт, «бичил санах ой буюу контакт бүхий чип»-ийг баруун захад, картын бичвэрийг ар дэвсгэртэй нягт уялдуулан цагаан өнгөөр, дахин давтагдахгүйгээр үргэлжилсэн алхан хээ ууссан бүдэг хөх өнгийн дэвсгэр дээр картын доод хэсэгт тус тус байрлана.

1.2. Картын нүүрэн талын дүрслэл, бичиглэл нь дараах хэмжээс, нөхцлийг хангасан байна. Үүнд:

1.2.1. “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн бичвэр нь иргэний үнэмлэхийн дээд талаас 6 мм зайд, “УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР” гэсэн бичвэр нь иргэний үнэмлэхийн дээд талаас 9 мм зайд голлон цагаан өнгөөр хэвлэгдсэн байна;

1.2.2. Улсын бүртгэлийн ерөнхий газрын лого нь 14.5 мм өндөр, 10 мм өргөнтэй, иргэний үнэмлэхийн дээд талаас 2 мм, зүүн талаас 2.5 мм зайд байрлана;

1.2.3. картын баруун доод хэсэгт 8 орон бүхий сериалын дугаар картын доод талаас 7 мм зайд, зүүн талаас 7 мм зайд алхан хээний дээд талд цагаан өнгөөр байрлана;

1.2.4. картын баруун талаас 5 мм, доод талаас 1.5 мм зайд 1.75 мм өндөр, 2.75 мм өргөнтэй бичил санах ой буюу чип байрлана;

1.2.5. картын доод талаас 1 мм зайд 85.60 мм урттай алхан хээ байрласан байна;

1.2.7. “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг”, “УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР” гэсэн бичвэрийн доор “Аймаг /Нийслэл; Сум/ Дүүрэг; Хороо”

гэсэн бичвэр хоорондоо 6 мм зайтай доош нэг эгнээнд байрлах бөгөөд “Сериал: 00000000” гэсэн бичвэр өмнө бичвэрээс 9 мм зайтай, бичвэрүүд нь цагаан өнгөтэй байна.

Хоёр. Картын ар тал

2.1. Иргэний үнэмлэхийн бичил санах ойд мэдээлэл оруулах картын ар талд дээд, доод хоёр талаараа алхан хээгээр хүрээлэгдсэн байхаас гадна «Монгол Улсын иргэний цахим үнэмлэхийн бичил санах ойд мэдээлэл оруулахад ашиглана» гэсэн бичвэрийг гурван мөрөнд багтаан үнэмлэхийн төв хэсэгт голлуулан, бичвэрийн ар талд төрийн бэлэгдэл соёмбо бүдэг байрлах бөгөөд, соёмбын ар дэвсгэрт Монгол улсын газрын зураг давхар картын төв хэсэгт хөх цэнхэр, бүдэг цэнхэр өнгөн дээр байрласан байна.

2.2. Картын ар талын дүрслэл, бичиглэл нь дараахь хэмжээс, нөхцлийг хангасан байна. Үүнд:

2.2.1. картын дээд талаас 2 мм болон доод талаас 1 мм зайд хоорондоо 43 мм зайтай 85.60 мм урттай алхан хээ байна;

2.2.2. картын дээд талаас 14 мм, зүүн талаас 25 мм зайд 15 мм өндөр, 25 мм өргөнтэй соёмбо байрлана;

2.2.3. картын зүүн талаас 5 мм, дээд талаас 22 мм зайд 11 мм өндөр, 19 мм өргөнтэй иргэний цахим мэдээллийг хадгалах бичил санах ой /чип/ байрлана;

2.2.4. иргэний үнэмлэхийн төв хэсэгт тусгаар тогтнол, газар нутгийн бэлэгдэл Монгол Улсын газрын зураг голлон байрлана;

2.2.5. үнэмлэхийн зүүн талаас 33 мм, дээд талаас 22 мм зайд «Монгол Улсын иргэний цахим үнэмлэхийн бичил санах ойд мэдээлэл оруулахад ашиглана», үнэмлэхийн зүүн талаас 15 мм, доод талаас 10 мм зайд “Энэхүү карт нь төрийн өмч бөгөөд бусад зорилгоор ашиглах, хөндлөнгийн этгээдэд дамжуулах, эзэмшүүлэхийг хориглоно” гэсэн бичвэр тус тус байрлах бөгөөд бичвэр нь цагаан өнгөөр бичигдсэн байна.

Монгол Улсын иргэний үнэмлэхийн бичил санах ойд мэдээлэл оруулах карт нь дараах стандартуудад нийцсэн байх шаардлагатай. Үүнд:

- ISO/IEC 7810 ID Card Физик шинж чанар;
- ISO/IEC 7812 ID Card Контакттай интеграл схем;
- ISO10373-1 Механик тест уян хатан байдал;
- ISO10373-3 Механик тест уян даралт;
- ISO/IEC 7816-1 Физик шинж чанар;
- ISO/IEC 7816-2 Чипийн контактын хэмжээ, байршил;
- ISO/IEC 7816-3 Цахилгааны интерфэйс болон дамжуулалтын протокол;
- ISO/IEC 7816-4 Харилцан ажиллагааны команд;

- ISO/IEC 7816-5 Дугаарлалтын систем болон тусгай програм хангамж нийлүүлэгчдэд зориулсан процедур;
- ISO/IEC 7816-6 Өгөгдөл харилцан солилцох;
- ISO/IEC 7811 Иргэний цахим үнэмлэхэд бичлэг хийх аргачлалыг тайлбарлах.

---o0o---

Улсын бүртгэлийн ерөнхий
газрын даргын 2015 оны 150 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХИЙН БИЧИЛ
САНАХ ОЙД МЭДЭЭЛЭЛ ОРУУЛАХ КАРТЫН ЗАГВАР

Монгол Улсын иргэний үнэмлэхийн бичил санах ойд мэдээлэл оруулах нууцлал бүхий бэлдэц /түүхий эд/ нь физик шинж чанарыг тодорхойлсон олон улсын ISO 7810 стандарт болон ISO 10373 стандартын дагуу шалгагдсан байх бөгөөд картын хэмжээ нь ID 1 стандартад нийцсэн 85.60 мм х 53.98 мм хэмжээтэй поликарбонат материалаар хийгдсэн байна.

Картын
нүүрэн тал



Картын
ар тал

